



# МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ



# 2016



## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

### ЭРХЭМ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ТАНЫ ЭНЭ ӨДРИЙН АМГАЛАНГ АЙЛТГАЯ

Юуны өмнө та бүхэндээ энэ онд тохиож буй Монгол Улсад мэдээлэл, шуудан, харилцаа холбооны салбар үүсч хөгжсөний 95 жилийн ой, тэр дундаа салбарын ууган компани болох Монголын цахилгаан холбоо ХК үүсэн байгуулагдсаны түүхт 95 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Бидний амжилтыг хамтдаа бүтээлцэж буй эрхэм хувьцаа эзэмшигчид, харилцагч Та бүхэндээ 2015 онд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, үйл ажиллагааны ололт амжилт 2016 онд баримталж ажиллах зорилтуудаа хүргэж байгаадаа баяртай байна.

Монголын цахилгаан холбоо ХК нь Монгол Улсын алслагдсан сум, суурин газар болон үйлчилгээ хүрээгүй хүн амд харилцаа холбооны үйлчилгээг хүргэх бүх нийтийн үйлчилгээний үүргийг хүлээж сум, суурин газрын төр захиргаа, төсвийн байгууллага, ЕБС, хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдэд өндөр хурдны өргөн зурвасын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас үүрэг болгосон чиглэлийн дагуу 2016 оны 03 сарын 15 өдрөөс орон нутагт интернэтийг “Ижил үнэ—Тэгш хурд”-аар өгөх боломж бүрдсэн. Ингэснээр орон нутагт харилцаа холбооны үйлчилгээний хүртээмж, үйлчилгээний чанар дээшлэх нөхцөл бүрдэхээс гадна хөдөө орон нутаг, хот суурин газарт газарзүйн байршлаас үл хамааран интернэтийн үйлчилгээг ижил үнэ тарифаар хүргэх, интернэтийн хэрэглээ өсөн нэмэгдэх өргөн боломж нээгдэж байна.

Бид 2015 онд газар зүйн байршлаас үл хамааран, интернэт холболттой бүх газраас үүрэн болон суурин холбооны бүх дугаар луу хамгийн хямдаар ярих боломжийг олгож буй SIP протоколд суурилсан урьдчилсан төлбөрт MiP70 үйлчилгээг зах зээлд нэвтрүүлээд байна. Мөн онлайн худалдаа, үйлчилгээг ашиглалтад оруулж, онлайнгаар төлбөр төлөх, бүх төрлийн урьдчилсан төлбөрт үйлчилгээний картуудыг хэрэглэгч банкны картаа ашиглан худалдан авах боломжийг бүрдүүлсэн.

Өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх зорилгоор интернэтийн өргөн зурвасын үйлчилгээний гурвалсан үйлчилгээг дэмждэг GPON шилэн кабелийн сүлжээг байгуулах ажлыг эхлүүлээд байна.

Манай компани 2016 онд суурин сүлжээ, хэрэглэгчийн болон шилэн кабелийн өргөтгөл шинэчлэл, УБ хот болон аймгийн төв, томоохон хотуудын гэр хороололд WiFi үйлчилгээний өргөтгөл хийх зэрэг томоохон хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн мэдээлэл, харилцаа холбооны зах зээлд эзэлж буй байр суурь, орлого сүүлийн жилүүдэд тасралтгүй буурч байгаа ч бид бүхэн 2016 онд бизнесийн өрсөлдөөнт орчинд аль болох зах зээлээ хадгалан үлдэх, шинэ технологи, үйлчилгээг нэвтрүүлэх, техник технологийн шинэчлэл хийх замаар үйлчилгээнийхээ чанар, хүртээмжийг сайжруулах тал дээр онцгой анхаарч ажиллах болно.

Компанийнхаа хөгжил, дэвшлийн төлөө хамтдаа тэмүүлж, өөрчлөлт, шинэчлэлтийг бодитойгоор хэрэгжүүлэхэд Та бүхний дэмжлэг туслалцаа чухал гэдгийг онцлон тэмдэглэхийг хүсч байна.

ТА БҮХНИЙ МААНЬ САНАСАН БҮХЭН СЭТГЭЛЧЛЭН БҮТЭХ БОЛТУГАЙ.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Т.БАТМАГНАЙ



## АГУУЛГА

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ.....	1
Компанийн танилцуулга.....	3
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах ТУЗ-ын тогтоол.....	4
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар.....	5
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг.....	5
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын танилцуулах баримт бичгийн жагсаалт.....	5
2015 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт.....	6
2015 оны үндсэн үйл ажиллагаа.....	8
2016 оны бизнес төлөвлөгөөний танилцуулга.....	11
2015 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт.....	15
Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн товч танилцуулга.....	20
2015 оны ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол.....	22
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл.....	23
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас.....	26



## МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэр: Монголын цахилгаан холбоо ХК  
Үндсэн харьяалал: Монгол Улс  
Хаяг: Энхтайваны өргөн чөлөө-1, Улаанбаатар-15160, ш/х 1166  
Утас: (976) 7010 2248, (976) 7010 2245  
Факс: (976) 7010 2245  
Улсын бүртгэлийн  
гэрчилгээний дугаар: 9012001002, регистр 2073943.

Монголын цахилгаан холбоо ХК нь анх 1921 онд “Шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороо” нэрээр байгуулагдсан Монгол Улсын ууган компани юм. Монголын цахилгаан холбоо ХК нь Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1995 оны 28 тоот тогтоол, Дэд Бүтцийн Хөгжлийн сайдын мөн оны 208 дугаар тушаалаар гадаадын хөрөнгө оруулалттай хувьцаат компани болон зохион байгуулагдсан. Нийт хувьцааны 54.67 хувийг Монгол Улсын Засгийн газар, 40.0 хувийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Кореа Телеком корпораци, 5.33 хувийг Монгол Улсын болон гадаадын иргэд тус тус эзэмшдэг.

Монголын цахилгаан холбоо ХК нь эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд улс, хот хооронд болон төв, орон нутагт цахилгаан холбоо, интернэт, кабелийн телевиз, лавлахын үйлчилгээг үзүүлдэг.

Харилцаа холбооны салбарт төрөөс баримталж буй бодлогын хүрээнд Засгийн газрын Цахилгаан холбооны сүлжээний төрийн өмчийн компани байгуулах тухай 2006 оны 186 дугаар тогтоолын дагуу тус компани Монголын цахилгаан холбоо ХК, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК болж салсан байна. Төрийн Өмчийн Хорооны шийдвэрээр 2009 онд Монголын цахилгаан холбоо ХК-ийн зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлтийг хийсэн.

### АЛСЫН ХАРАА

Харилцаа холбооны үндэсний брэнд компанийнхаа үйлчилгээг дэлхийн түвшинд хүргэнэ.

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Орчин үеийн технологийн хөгжилд тулгуурлан өндөр чанартай, бүх нийтийг хамарсан харилцаа холбооны үйлчилгээ үзүүлж, үндэсний анхдагч компанийн нэр хүндийг өндөрт өргөн, хэрэглэгчидтэйгээ хамт хөгжин урагшлах нь бидний эрхэм зорилго мөн.

### ҮНЭТ ЗҮЙЛС

- ХЭРЭГЛЭГЧ: Олон жилийн түншийн харилцаатай, үнэнч найдвартай хэрэглэгчид
- БРЭНД НЭР: Монголын харилцаа холбооны ууган компани “Mongolia Telecom” брэнд
- ХАМТ ОЛОН: Арвин туршлага бүхий компанидаа сэтгэл, чадвараа зориулсан ахмад, дунд, шинэ залуу үеийн үнэнч баг хамт олон
- ХАРИУЦЛАГА: Монгол орны онцлогт тохирсон чанартай үйлчилгээг хямд үнээр улс орон даяар бүх нийтэд хүргэх нийгмийн үүрэг, хариуцлага

### УРИА ҮГ

*“АМЬДРАЛЫН ХАРИЛЦАА БҮРИЙГ БИД ХОЛБОНО”*

## МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 132 ДУГААР ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 3 дугаар сарын 18-ны өдөр

№1

Улаанбаатар хот

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дэх заалтыг тус тус үндэслэн Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2016 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр 11:00 цагт Улаанбаатар хотод “Мэдээлэл Холбооны Сүлжээ” ТӨХХК-ийн хурлын зааланд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
  - 2.1 Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
  - 2.2 Компанийн 2015 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
  - 2.3 Компанийн аудитын хорооны тайлан
  - 2.4 ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийг сонгох
  - 2.5 ТУЗ-ийн 2016 оны зардлын төсвийг батлах
  - 2.6 Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийн тайланг хэлэлцэх
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2016 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдрөөс өдөр тутмын 2-оос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээллэх. Энэ мэдээллийг анх зар хүргэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2016 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр дахин зар гаргахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэг, танилцах баримт бичгийн жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар баталж хувьцаа эзэмшигчид 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 09<sup>00</sup>-18<sup>00</sup> цагийн хооронд “Монголын Цахилгаан Холбоо” ХК-ийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 2 дугаар хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдээс авах “Саналын хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харъяалагдах брокер, дилерийн компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 5-с доошгүй хоногийн өмнө байхаар тогтсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Захиргаа, удирдлагын газрын дарга Ж.Буяндалай, Хурал зохион байгуулах комиссын даргаар Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Галбадрах, гишүүдээр Х.Цэцэгмаа, Ж.Азбаяр, Тооллогын комиссын даргаар Ш.Нурдаулет, гишүүдээр Ц.Амгалан, Т.Баярцогт нарыг тус тус томилсугай.

## ӨДӨР ТУТМЫН ХЭВЛЭЛД ӨГСӨН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

### МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Монголын Цахилгаан Холбоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр 11:00 цагт Улаанбаатар хотод “Мэдээлэл Холбооны Сүлжээ” ТӨХХК-ийн хурлын танхимд болно.

Хаяг: Чингэлтэй дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө-1

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр:

2016 оны 3 дугаар сарын 31 өдөр

#### ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
2. Компанийн 2015 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
3. Компанийн аудитын хорооны тайлан
4. ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ-ийн 2016 оны зардлын төсвийг батлах
6. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийн тайлан

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 9:00-18:00 цагийн хооронд “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн байранд 306 тоот /Х.Цэцэгмаа/-с танилцах боломжтой.

**ХОЛБОО БАРИХ:** ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа

**УТАС:** 7010 2210

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

## МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

*Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 132 дугаар хурлын №1 тогтоолын Хавсралт-1*

1	Хурлын ирцийг бүртгэх (Зохион байгуулах комисс)	11:00-11:30
2	Хурлын ирцийг мэдээлэх (Зохион байгуулах комисс)	5 минут
3	Хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах (Хурлын дарга)	10 минут
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах	60 минут
5	Хурлын завсарлага	10 минут
6	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	10 минут
7	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
8	Хурлыг хаах (Хурлын дарга)	10 минут

## МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. Компанийн 2015 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
2. Компанийн 2015 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
3. Компанийн 2016 оны бизнес төлөвлөгөө
4. Компанийн аудитын хорооны тайлан
5. ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийн танилцуулга
6. ТУЗ-ийн 2016 оны зардлын төсвийн төсөл
7. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэр



## МЦХ ХК-ИЙН 2015 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### ОРЛОГО

2015 онд төлөвлөгөөний дагуу нийт 22,741.5 сая төгрөгийн орлоготой ажиллахаас гүйцэтгэлээр 20,573.3 сая төгрөгийн орлоготой ажилласан.

Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны орлого 87.3 хувийн биелэлттэй буюу 2,807.5 сая төгрөгөөр тасарсан нь зарим нэр төрлийн орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой. Үүнд, улс хоорондын ярианы үйлчилгээний орлого 166.2 сая төгрөг, суурин утасны үйлчилгээний орлого 1,643.1 сая төгрөг, интернет үйлчилгээний орлого 371.7 сая төгрөг, лавлах үйлчилгээний орлого 358.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Үндсэн бус үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 639.4 сая төгрөгөөр биелсэн үзүүлэлттэй гарсан нь байгууллагын хадгаламжийн болон харилцахын хүүгийн орлого, ханшийн зөрүүнээс орсон орлогын төлөвлөгөө давж биелсэнтэй холбоотой.

### ЗАРДАЛ

Жилийн эцсийн зардлын төлөвлөгөөгөөр нийт 23,479.4 сая төгрөгийн зардалтай ажиллахаас 21,235.7 сая төгрөгийн зардал гарган 2,243.6 сая төгрөг буюу 9,6 хувиар зардал хэмнэсэн үзүүлэлттэй гарсан.

Үндсэн үйл ажиллагааны зардал 2,330,4 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан нь сүлжээ ашиглалтын төлбөрийг 225,7 сая төгрөгөөр, сувгийн түрээсийн зардлыг 485,5 сая төгрөгөөр, техникийн засвар үйлчилгээг 331,9 сая төгрөгөөр, зар сурталчилгааны зардлыг 302,7 сая төгрөгөөр тус тус хэмнэн ажилласантай холбоотой.

### АШИГ

Тайлант хугацаанд 737.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 728.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.

### 2015 ОНЫ ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

/сая.төг/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2015 оны төлөвлөгөө	2015 оны гүйцэтгэл	Биелэлтийн хувь	Өсөлт, бууралт
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	22,134.9	19,327.3	87.3%	(2,807.5)
2	Үндсэн үйл ажиллагааны зардал	22,672.7	20,342.3	89.7%	(2,330.4)
3	Үндсэн үйл ажиллагааны ашиг	(537.9)	(1,015.0)	188.7%	(477.1)
4	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	606.5	1,246.0	205.4%	639.4
5	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	806.6	893.395	110.8%	86.8
6	EBITDA	2,828.0	2,456.0	86.8%	(372.0)
7	Үндсэн хөрөнгийн элэгдэл	3,365.9	3,470.9	103.1%	105.0
8	ЕБИТ	(737.9)	(662.4)	89.8%	75.5
9	Орлогын албан татвар	-	66.341	-	66.3
10	Цэвэр ашиг	(737.9)	(728.8)	98.8%	9.1

## 2015 ОНЫ АВЛАГА, ӨГЛӨГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### АВЛАГА

д/д	Дансны төрөл	Дүн	2015 он		Гүйцэтгэл %	2016 он Төлөвлөгөө
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Дансны авлага	3,586.3				
2	Бусад авлага	1,805.3				
3	Татвар, НДШ, УТТ	1,031.5	Татвар, НДШ-ийн илүү төлөлт болон урьдчилж төлсөн тооцоо дараагийн тайлант хугацаанд суутган тооцуулна			
	ДҮН	6,423.1				
	Авлагын үлдэгдэл	6,423.1	6,504.2	6,423.1	101%	6,373.9

Авлага өмнөх оноос 716.4 сая төгрөг буюу 11 хувиар буурч, төлөвлөгөөнөөс 101 хувийн биелэлттэй гарлаа. Үүнд, гадаад тооцооны авлага 238.3 сая төгрөг, харилцан холболт, сувгийн түрээсийн авлага 86,5 сая төгрөг, хэрэглэгчийн авлага 49,9 сая төгрөгөөр буурсан байна.


### БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

д/д	Дансны төрөл	Дүн	2015 он		Гүйцэтгэл %	2016 он Төлөвлөгөө
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Дансны өглөг	2,524.6				
2	Урьдчилж орсон орлого	829.0	Хэрэглэгчээс орж ирсэн урьдчилгаа төлбөр тайлант хугацаанд нь орлогоор тооцно			
	ДҮН	3,353.6				
	Өглөгийн үлдэгдэл	3,353.6	2,598.5	3,353.6	77%	3,874.3

Өглөг өмнөх оноос 524.6 сая төгрөгөөр буюу 13.5 хувиар буурсан боловч төлөвлөгөөний биелэлт 77 хувьтай байна. Үүнд, 150 сумын төслийн дэд бүтэцтэй холбоотой өглөг нөлөөлсөн.

### МЦХ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ХАНШ

МЦХ ХК-ийн одоогийн үйл ажиллагаа, хөгжлийн чиг хандлагыг илэрхийлэх компанийн хувьцаа сарын дундаж ханшаар 12 дугаар сард 838 төгрөг болж өмнөх сарын үзүүлэлтээс 91 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Сүүлийн саруудын үзүүлэлтээс харахад хувьцааны ханш тогтворгүй, буурсан үзүүлэлттэй байна.





## 2015 ОНЫ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### СУУРИН УТАСНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилт: Суурин утасны цэгийн тоог 78,266-д хүргэх  
Биелэлт: 96.6%

#### Хийж гүйцэтгэсэн томоохон ажлууд

- Онлайн үйлчилгээний салбар болох mtonline.mn вэб сайтыг ашиглалтанд оруулж, хэрэглэгчид үйлчилгээний төлбөрөө онлайнгаар төлөх, бүх төрлийн урьдчилсан төлбөрт үйлчилгээний картуудыг банкны кредит картаар худалдан авах боломжийг бүрдүүлсэн. Мөн Худалдаа хөгжлийн банк, Хаан банк, Төрийн банк, Голомт банкны онлайн үйлчилгээг ашиглах боломжтой болсон.
- SIP протоколд тулгуурласан интернэт ярианы MiP70 үйлчилгээг зах зээлд шинээр амжилттай нэвтрүүлж, зорилтот зах зээлийн тодорхой хувьд бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргээд байна.
- Уламжлалт суурин утаснаас дараа үеийн суурин утасны (NGN) технологи руу 1,800 гаруй хэрэглэгчийг шилжүүлснээр үйлчилгээний чанар сайжирч, ашиглалтын зардлыг багасгасан.
- Улирлын шинжтэй маркетингийн идэвхижүүлэлт, урамшууллын хөтөлбөрүүдэд 17,000 гаруй хэрэглэгч хамрагдсан.

#### Хүчин зүйлсийн шинжилгээ

##### Гадаад хүчин зүйлс:

- Өрсөлдөөний байдал, хэрэглэгчдийн хэрэглээний өөрчлөлт нь хэрэглэгчийн тоонд ихэнх хувийг эзэлдэг хувь хэрэглэгчдийн гэрээ цуцлалтын үндсэн шалтгаан болж, цэгийн тооны бууралтад нөлөөлж байна.
- Гурвалсан үйлчилгээ үзүүлэгчдийн эрчимтэй үйл ажиллагаанаас шалтгаалан орон нутагт томоохон зах зээл эзэлдэг Орхон, Дархан-Уул аймагт хэрэглэгчийн тоо буурч, цэгийн тооны биелэлт Орхон-69%, Дархан-уул -72% байна.

##### Дотоод хүчин зүйлс:

- Одоогийн биллинг систем нь хэрэглэгчийн төлбөр төлөлттэй холбоотой төрөл бүрийн хөнгөлөлт урамшууллыг дэмжихгүй байна.
- Орон нутагт үйлчилгээ хүргэх зардал өндөр байгаа нь үнийн дорвитой өөрчлөлт хийхэд сөргөөр нөлөөлж байна.

### ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилт: Интернэт хэрэглэгчийн тоог 29,987-д хүргэх  
Биелэлт: 80.6%

#### Хийж гүйцэтгэсэн томоохон ажлууд

- Сумдад интернэт хүргэх төслийн хүрээнд шинээр "UTM5" биллинг системийг нэвтрүүлэн, нийт 161 суманд Миком WiFi интернэтийн картын үйлчилгээг хүргээд байна.
- Боловсрол соёл, шинжлэх ухааны яамтай хамтран "Сумын төвийн ерөнхий боловсролын сургуулиудад интернэт хүргэх" төслийг үргэлжлүүлэн 228 сумын 239 сургуульд бодит хурдаар интернэт үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан үйлчилгээгээ хүргэж байна.
- Шангри-Ла Улаанбаатар ХХК-тай "50МВ бодит хурдны интернэтийн үйлчилгээ"-ний гэрээ, Монгол даатгал компанийн 21 аймгийн салбарт интернэтийн үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан.

#### Хүчин зүйлсийн шинжилгээ

##### Гадаад хүчин зүйлс:

- Орон нутгийн зах зээлийн багтаамжийн дийлэнх хувийг /30% орчим/ эзэлдэг аймгуудын цэгийн тооны биелэлт хамгийн доогуур үзүүлэлттэй, тухайлбал, Орхон 43%, Дархан-Уул 63%, Налайх 65% тус тус биелэлттэй байна. Эдгээр аймгууд болон Улаанбаатарт гурвалсан үйлчилгээний операторууд идэвхитэй үйл ажиллагаагаа явуулж байгаа нь гэрээ цуцлалтыг нэмэгдүүлж байна.

#### Дотоод хүчин зүйлс:

- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад шинэ холболтын тоо 45%-иар буурсан ба шинэ хэрэглэгч нэмэгдүүлэх идэвхжүүлэлтийн ажил хийхэд интернэт модемны нөөцгүй байсан нь шууд сөргөөр нөлөөлсөн.
- Мөн хэрэглэгчийн портыг чөлөөлөх зорилгоор идэвхгүй 1,100 гаруй хэрэглэгчийн гэрээг цуцалсан.

#### КАБЕЛИЙН ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

**Зорилт:** КаТВ хэрэглэгчийн тоог 14,521-д хүргэх

**Биелэлт:** 102.6%

#### Хийж гүйцэтгэсэн томоохон ажлууд

- Улаанбаатар хот болон аймгуудад MSAN суурилуулсан барилгуудад борлуулалт, идэвхжүүлэлт хийж цэгийн тоог нэмэгдүүлсэн.
- Телевизийн өргөн нэвтрүүлгийн аналог системийг тоон технологид шилжүүлэх ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

#### Хүчин зүйлсийн шинжилгээ

2014 оны 12 сарын 31-ны байдлаар хэрэглэгчийн тоо 15,131 байсан ба 2015 онд 610 цэгээр бууруулахаар төлөвлөж, 2015 оны эцсийн статистик мэдээгээр хэрэглэгчийн тоо 14,906 болж, өмнөх онтой харьцуулахад 225-аар буурсан байна. Хэрэглэгчийн тоо буурч байгаад дараах хүчин зүйлс голчлон нөлөөлж байна.

#### Гадаад хүчин зүйл

Бусад компанийн интернэт технологид суурилсан гурвалсан үйлчилгээ УБ болон орон нутагт эрчимтэй нэвтэрч, тэдгээрийн технологийн давуу байдал, хүчтэй маркетинг нь хэрэглэгчийн цуцлалт нэмэгдэхэд хүргэж байна.

#### Дотоод хүчин зүйл

Кабелийн телевизийн технологи хоцрогдолд орж чанартай үйлчилгээ хүргэж чадахгүй байгаа нь хэрэглэгчийн сэтгэл ханамжид нөлөөлж, гэрээ цуцлалтын тоо ихэсч байна.

#### ЛАВЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

**Зорилт:** Лавлах үйлчилгээний дуудлагын тоог өдөрт 7,000-д хүргэх

**Биелэлт:** 43%

#### Хийж гүйцэтгэсэн томоохон ажлууд

- 1900-1109 лавлах төвийн зарын вэб сайт, ухаалаг төхөөрөмжүүдэд зориулагдсан мобайл аппликэшн хийгдсэн.
- Хэрэглэгчийн лавласан мэдээллийг давхар мессежээр хүргэх үйлчилгээг нэвтрүүлсэн.
- Ном, сонин сэтгүүл, CD, тоглолтын билет хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлсэн.
- МТС-300 идэвхжүүлэлтийн хөтөлбөр амжилттай хэрэгжсэн.

#### Хүчин зүйлсийн шинжилгээ

#### Гадаад хүчин зүйл

- ХХЗХ-ны 2014 оны 11-р сарын 38-н тоот тушаалаар баталсан журмын дагуу хэрэглэгчдэд үйлчилгээний тарифыг урьдчилан мэдэгдэж байгаа нь амжилтгүй дуудлагын тоог эрс нэмэгдүүлсэн.

#### Дотоод хүчин зүйл

- 2014 онд “1109 лавлах төвийг шинэчлэх” төсөлд 1 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалт хийн хэрэгжүүлэх байсан тул орлогын төлөвлөгөөг өнгөрсөн оны гүйцэтгэлээс 200 саяар нэмэгдүүлэн төлөвлөсөн. Уг төслийг хугацаа алдаж хэрэгжүүлж эхэлсэн нь орлогын төлөвлөгөө тасрах гол шалтгаан болсон.
- Төсөл хугацаандаа хэрэгжээгүйгээс шалтгаалан сүүлийн хагас жилд маркетинг, идэвхжүүлэлтийн төлөвлөсөн ажлууд хийгдээгүй.



## УЛС ХООРОНДЫН ЯРИАНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

**Зорилт:** Улс хоорондын ярианы үйлчилгээг зах зээлд дахин байршуулж, ярианы тариф бусдаас хямд, харьцуулашгүй сувгийн чанар зэрэг давуу талуудаа хэрэглэгчдэд таниулах замаар улс хоорондын ярианы ачааллаа нэмэгдүүлж ажиллах.

**Биелэлт:** 84.3%

### Хийж гүйцэтгэсэн томоохон ажлууд

- Интернэтийн бөөний урсгалын 1 Mbps үнийг бууруулж, урсгалын хэмжээг өмнөх оныхоос 150 Mbps-аар нэмэгдүүлж, төлбөрийн нөхцлийг өөрчлөн гэрээ байгуулсан.
- RosTelecom компанийн дамжуулах байгууламжийн зардлыг 51 хувиар бууруулсан.
- SingTelecom, KazTelecom, DeutscheTelecom, ARIATelecom, Cogent Telecom компаниудтай VoIP гарц нээхээр хамтран ажиллаж, SingTelecom компанитай IP холболт хийж, хамтран ажиллаж байна.
- KDDI-ийн TDM сувгийг хааж, IP руу шилжүүлсэнээр жилд 29.7 сая төгрөгийн зардал бууруулсан.
- Орох ачааллын 85-90 хувийг эзлэж байгаа КТ корпорацитай ачаалал нэмэгдүүлэх гэрээг шинэчлэн байгуулсан.
- КТ, AT&T, RosTelecom-тай гэрээг шинэчлэн, өмнөх жилүүдийн сувгийн төлбөр тооцоог хийж дуусгасан.

### Хүчин зүйлсийн шинжилгээ

#### Гадаад хүчин зүйлс

- Сүүлийн жилүүдэд интернэтэд суурилсан телефон ярианы үйлчилгээ өргөжиж гарах, орох ярианы таталцалд хүчтэй нөлөөлж байгаагаас улс хоорондын ярианы үндсэн гарцаар дамжих ярианы ачаалал буурч, интернэт протоколд суурилсан улс хоорондын яриа руу ачаалал шилжиж байна.
- Улс хоорондын телефон яриаг орлох илүү хямд өртөгтэй техник, технологийн боломжууд бий болсон.

#### Дотоод хүчин зүйлс

- Улс хоорондын телефон ярианы таталцааны 90-95 хувь нь үүрэн холбооны сүлжээн дээр үүсэж байгаа.
- Улс хоорондын үйлчилгээнд зориулсан идэвхжүүлэлт хийгдээгүй.

Бүтээгдэхүүн үйлчилгээний

- Лавлагаа, мэдээлэл
- Шинэ үйлчилгээ
- Гэмтэл саатал
- Санал хүсэлт хүлээж авна



# 7000-8000

*Амьдралын харилцаа бүрийн бид холбоно.*



## 2016 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАНИЛЦУУЛГА

### I. 2016 ОНЫ ҮНДСЭН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛТ СУУРИН УТАСНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилт:

Хэрэглэгчийг халамжлан, гэрээ цуцлалтыг бууруулж, зах зээлд эзлэх байр суурийг хадгалан үлдэх

- Үнэ тарифын өрсөлдөхүйц уян хатан бодлого баримтлах, үүрэн сүлжээнд гарах ярианы тарифыг бууруулах
- Үнэнч болон найдвартай хэрэглэгчдэд зориулсан гишүүнчлэлийн хөтөлбөр хэрэгжүүлэх
- Үйлчилгээний чанарыг сайжруулах
- 70хх \*\*\*\* дугаарын үнэ цэнийг нэмэгдүүлэх, нийгэмд хоногшуулах

Нэмэлт үйлчилгээний хэрэглээг өсгөж, нэг хэрэглэгчээс орох дундаж орлогыг өсгөх

- Дараа үеийн суурин утасны станцийн боломжуудад тулгуурлан нэмэлт үйлчилгээг хэрэглэгчдэд таатай нөхцлөөр санал болгох
- Нэмэлт үйлчилгээний хэрэглээг дэмжих урамшуулал хэрэгжүүлэх
- SIP протоколд суурилсан үйлчилгээний төрлийг нэмэх
- Урьдчилсан төлбөрт үйлчилгээнд нэгжийн зээл, нэгж шилжүүлэх үйлчилгээ нэвтрүүлэх
- Багц ярианы үйлчилгээ нэвтрүүлэх

Байгууллагын хэрэглэгчийн зах зээлд эзлэх хувийг нэмэгдүүлэх

- Байгууллагын хэрэглэгчдэд зориулсан үнэнч, найдвартай хэрэглэгчийн хөтөлбөр хэрэгжүүлэх
- SIP-Trunk үйлчилгээг нэвтрүүлэх
- Нэмэлт үйлчилгээнд тулгуурлан байгууллагын хэрэгцээнд нийцсэн багц бүтээгдэхүүнийг санал болгох
- Байгууллагын хэрэглэгч рүү чиглэсэн сурталчилгаа, идэвхижүүлэлтийг сайжруулах

### ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилт: Хэрэглэгчийг халамжлан, гэрээ цуцлалтын тоог бууруулж, хуучин хэрэглэгчдийг тогтоон барих

- Үнэнч, найдвартай хэрэглэгчдийг халамжлах /Loyalty, VIP карт гаргах/
- Үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, онлайн борлуулалт, төлбөр тооцооны системийг нэвтрүүлэх
- Идэвхгүй хэрэглэгчдийг идэвхжүүлэх, өрсөлдөхүйц үнэ тарифын уян хатан бодлого баримтлах

Техникийн шинэ шийдлээр хэрэглэгчдэд өндөр хурдны интернэтийн үйлчилгээ үзүүлж, хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх

- Өндөр хурдны интернэтийн үйлчилгээ VDSL2 /GPON сүлжээ/
- Багцын үйлчилгээг өрхийн болон байгууллагын хэрэгцээнд тохируулан хямд өртгөөр нэвтрүүлэх

Wi-Fi интернэт үйлчилгээний хэрэглэгчдийг нэмэгдүүлэн зах зээлээ тэлэх

- Үйлчилгээний хүрээг тэлэн боломжит зах зээлд Wi-Fi интернэтийн үйлчилгээг нэвтрүүлэх
- Wi-Fi сүлжээний нэгдсэн хяналт удирдлагын төв байгуулах

Интернэт үйлчилгээний хавсарга бүтээгдэхүүнүүдийг идэвхжүүлэх

- Байгууллагын хэрэглэгчдэд зориулан Дата центр, VPN зэрэг үйлчилгээнүүдийг идэвхжүүлэх



## КАБЕЛИЙН ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилт:

Хуучин хэрэглэгчээ тогтоон барьж зах зээлд эзлэх хувийг хадгалан үлдэх, хэрэглэгчийг халамжлан, цуцлалтын тоог бууруулах

- Одоогийн үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд гарч буй сувгийн тоог нэмэх, гаралтыг сайжруулах,
- Хэрэглэгчийн гомдлыг шуурхай шийдвэрлэх
- Үнийн уян хатан бодлого баримтлах зэргээр хэрэглэгчийг халамжлан, хуучин хэрэглэгчээ тогтоон барьж, цуцлалтын тоог 20 хувиар бууруулах

Одоогийн нөхцөл боломжид тулгуурлан борлуулалтыг ихэсгэх

- Шинээр ашиглалтанд орж буй барилга, орон сууцанд MSAN төхөөрөмжийг байршуулах
- Өрсөлдөгчдийн хүрч амжаагүй захын дүүргүүдэд үйлчилгээгээ хүргэх
- Биечилсэн борлуулалт, идэвхжүүлэлтийг хийх зэргээр шинэ хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

Боломжит зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадвар бүхийн шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлж, зах зээлд эзлэх хувийг өсгөх

- Орлого олох боломжит аймгуудад DVB-T2 тоон системд шилжүүлж хэрэглэгчийг lock/in хийх
- 3 төрлийн сувгийн багц үйлчилгээг нэвтрүүлэх, үнийн урамшуулал олгох
- Багцын шилдэг сувгуудыг сурталчилан идэвхжүүлэх зэрэг үйл ажиллагааг аймаг тус бүр дээр хэрэгжүүлнэ.
- Агаарын олон сувгийн телевизийн үйлчилгээг орон нутагт нэвтрүүлэх

## ЛАВЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилт:

Үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх

- Хүргэлтийн үйлчилгээг өргөжүүлэх, нэр төрлийг олшруулах
- ТВ зарын сайт, зарын сонинг бүрэн ажиллагаанд оруулах
- Mobile application-д тулгуурласан лавлагааны үйлчилгээг идэвхижүүлэх
- Телемаркетингийн үйлчилгээг шинээр нэвтрүүлэх

Үйлчилгээний чанарыг сайжруулах, мэдээллийн санг баяжуулах

- Мэдээллийн санг шинэчлэх
- Мэдээллийн үнэн зөв байдлын хяналтыг сайжруулах
- Мэдээллийн сан бүрдүүлэх системийг боловсронгуй болгоход чиглэсэн ажлуудыг хэрэгжүүлнэ.

## ОЛОН УЛСЫН ЯРИАНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилт:

- Суурин утаснаас бусад гарцуудыг ашиглаж улс хоорондын үйлчилгээ авч байгаа хэрэглэгч рүү чиглэсэн ажлыг зохион байгуулах
- Интернэтийн гадаад бөөний урсгалыг үр ашигтай хувиарлах
- 001, VoIP гарцуудыг тогтмол хэрэглэдэг хэрэглэгч, гадаадын хөрөнгө оруулагч болон олон улсын байгууллагууд руу хандсан идэвхжүүлэлтийн үйл ажиллагаа явуулах
- Олон Улсын карьер орнуудын хамтын ажиллагааг дээшлүүлэх, TDM гарцуудыг IP руу шилжүүлэх, шинээр гарц нээх үйл ажиллагааг дэмжих ажлыг хийхээр төлөвлөж байна.

## II. 2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОМООХОН ТӨСЛҮҮД

Суурин сүлжээний өргөтгөл шинэчлэл

Төслийн зорилго:

- IGW станцыг IP протоколд суурилсан хэрэглэгчийн болон холбох шугамын лиценцээр өргөтгөх, төвлөрсөн бүтэц бүхий PSTN станцуудыг тархмал бүтэцтэй NGN-н ONT/ONU-р солих, одоо ашиглагдаж буй Softswitch системийг өргөтгөж байгаа IGW-аар орлуулах
- NGN, ONT/ONU-уудыг холбох GPON шилэн кабелийн сүлжээ байгуулах
- Ашиглалт, үйлчилгээний зардал хэмнэж, IMS-д суурилсан нэмэлт үйлчилгээнүүдийг бий болгох зорилготой.

Хэрэглэгчийн болон шилэн кабелийн өргөтгөл шинэчлэл

Төслийн зорилго:

- Улаанбаатарт 10G цагираг сүлжээг өргөтгөх
- Улаанбаатарт утас, интернэтийн хэрэглэгчийн кабелийг өргөтгөх
- Орон нутагт утас, интернэт, КаТВ-ийн хэрэглэгчийн кабелийг өргөтгөх

Уг төслийг хэрэгжүүлсэнээр Улаанбаатар шилэн кабелийн цагираг сүлжээг өргөтгөх, МЦХ ХК-ийн үйлчилгээ хүрээгүй Улаанбаатар, аймгуудын алслагдсан хэсгүүдэд хэрэглэгчийн кабелийн сүлжээ байгуулах, кабелийн чанар болон техникийн бэлэн байдлыг сайжруулах, шаардлага хангаагүй кабелиас шалтгаалсан үйлчилгээний чанартай холбоотой хэрэглэгчийн гомдол буурна.

## III. 2016 ОНЫ КОМПАНИЙН АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Орлогын төлөвлөлт

МЦХ ХК-ийн харилцаа холбооны зах зээлд эзэлж буй байр суурь, орлого үйлчилгээ сүүлийн жилүүдэд тасралтгүй буурч байгаа хэдий ч 2016 онд бизнесийн өрсөлдөөнт орчинд аль болох зах зээлээ хадгалан үлдэх, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх, техник технологийн шинэчлэл хийх замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж УБ хот болон аймаг, дүүргийн холбооны газрын орлогыг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллахаар зорилт тавьж байна.

2016 онд нийт **20,851.9** сая төгрөгийн орлоготой ажиллахаар төлөвлөснөөс үндсэн үйл ажиллагаанаас **20,252.2** сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагаанаас **599.8** сая төгрөгийн орлоготой ажиллана гэж төлөвлөсөн. Нийт орлогын **97.1%** үндсэн үйл ажиллагааны орлого, **2.9%** үндсэн бус үйл ажиллагааны орлого байна.

Зардлын төлөвлөлт

2016 оны зардлын төлөвлөгөөг шинэ техник технологи нэвтрүүлэх, үйлчилгээний хүрээ, тоо хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулж хүртээмжийг дээшлүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэх замаар өртөг, зардлыг бууруулах, ашиглалтын зардлыг хэмнэлттэй, зохистой зарцуулах зарчмыг баримтлан боловсруулсан.

Компанийн орлого буурч байгаатай холбогдуулан ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор зардлыг боломжтой хэмжээнд хэмнэх зорилт дэвшүүлэн 2016 оны зардлын төсвийг **21,220.8 сая** төгрөгөөр төлөвлөсөн.

Ашгийн төлөвлөлт

Компанийн сүүлийн жилүүдийн бизнесийн үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ, харилцаа холбооны зах зээлд гарч буй өөрчлөлтүүд зэрэгт үндэслэн 2016 онд нийт **20,851.9 сая** төгрөгийн орлого олж, **21,220.8 сая** төгрөгийн зардал гарган **415,6 сая** төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөгөөг боловсруулсан.





№	Үзүүлэлт	2015 оны гүйцэтгэл	2016 оны төлөвлөгөө	2016 /2015	
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	19,327.4	20,252.2	104.8%	924.8
2	Үндсэн үйл ажиллагааны зардал	20,342.4	20,230.4	99.4%	(111.9)
3	Үндсэн үйл ажиллагааны ашиг	(1,015.0)	21.7	-2.1%	1,036.7
4	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1,246.0	599.8	48.1%	(646.2)
5	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	893.4	990.4	110.9%	97.0
6	ЕБИТДА	2,456.0	3,228.2	131.4%	772.2
7	Үндсэн хөрөнгийн элэгдэл	3,470.9	3,206.5	92.4%	(264.4)
8	ЕБИТ	(662.4)	(368.9)	55.7%	293.5
9	Орлогын албан татвар	66.3	46.7	70.5%	(19.6)
10	Цэвэр ашиг	(728.8)	(415.6)	57.0%	

#### 2016 ОНД ТӨЛӨВЛӨСӨН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮД

